



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ТУХАЙ ХУУЛЬ/ ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСӨЛД
ХИЙСЭН
ЗАРДЛЫН ТООЦОО**

2023

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот

Судалгааг удирдсан:

Х.Эрдэм-Ундрах

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал,
хууль зүйн ухааны доктор (Dr.jur)

Судалгааны багийн гишүүд:

М.Түвшинжаргал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
хууль зүйн ухааны доктор (Ph.D)

Б.Энх-Амгалан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан,
хууль зүйн ухааны магистр (LL.M)

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан

Х.Санчир

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	4
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	5
2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох	16
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	20
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	26
2.4. Үр дүнг тооцох	27
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах	29
III. ДҮГНЭЛТ, САНАЛ	30

ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

(ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН
ТӨСӨЛ)

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулиудын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж өргөн мэдүүлэхээр тусгасны дагуу Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөлд Цэцийн гишүүнд тавих шаардлага, Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, түүний бүрэн эрх эхлэх, үргэлжлэх, дуусах үндэслэл, түүнийг нэр дэвшүүлэх, томилох хугацаа, журам, ил тод байдлыг хангах, Цэцийн гишүүний хариуцлага, түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, эгүүлэн татах үндэслэл, журам, Цэцийн гишүүний хараат бус, халдашгүй байдлын болон эдийн засаг, нийгмийн баталгааг нарийвчлан зохицуулжээ.

Мөн Цэцийн болон түүний дарга, гишүүний бүрэн эрх, Цэцэд маргаан хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнийг тодорхойлж, маргаан хянан шийдвэрлэхээс бусад асуудлыг нийт гишүүнийхээ оролцоотой шийдвэрлэдэг Цэцийн зөвлөгөөний эрх зүйн үндэслэлийг бий болгох, Цэцийн Тамгын газрын чиг үүрэг, бүтэц, орон тоо, Цэцийн үйл ажиллагааны болон санхүүгийн бие даасан байдал, түүний баталгааг зохицуулах замаар Цэцийн зохион байгуулалт, бие даасан байдлыг дээшлүүлэхээр зорьсон байна.

Судалгааны зорилго. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, хялбарчлах болон бууруулах боломжит хувилбар бүхий санал боловсруулан, зардал, үр өгөөжийн харьцааг үнэлэхэд энэхүү судалгааны зорилго чиглэгдэнэ.

Уг хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд үүрэг үүсгээгүй бөгөөд төсөл хэрэгжихтэй холбогдон иргэн, хуулийн этгээдэд зардал гарахгүй тул энэхүү зардлын тооцоог гагцхүү төрийн байгууллагад учрах зардлын тооцоогоор хязгаарлав.

Ингэхдээ гагцхүү нэмэлтээр орсон эсхүл өөрчлөгдсөн чиг үүрэгтэй холбоотой зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов. Өөрөөр хэлбэл, өөрчлөгдөөгүй буюу өмнө нь байсан чиг үүрэгтэй холбогдох аливаа зардлыг тус судалгааны хүрээнд тооцоогүй болно.

Түүнчлэн, Цэцийн гишүүний туслахын хэрэгжүүлэх чиг үүрэг болон үндсэн эрх зөрчигдсөн талаарх гомдолтой холбоотой маргаан хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй холбоотой зардлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хийсэн зардлын тооцоонд тусгасан.

Судалгааны үр дүнд үндэслэн, тус хуулийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг тооцон, зардал ба үр өгөөжийн харьцааг дүгнэж тайлан боловсруулав.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцно. Уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, зардал, ажлын ачаалалд нөлөө үзүүлэх боломжтой зохицуулалтыг сонгож авахдаа дараах чиг үүргийг “одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд тусгагдсан” гэсэн үндэслэлээр энэхүү зардлын тооцоонд оруулаагүй болно. Үүнд:

- 6.4.Ерөнхийлөгч Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгох тухай захирамж гаргана;
- 6.7.Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо энэ хуулийн 6.2-т заасны дагуу санал болгосон нэр дэвшигчийн сонсголыг холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулна;
- 6.8.Нэр дэвшигчийг Улсын Их Хурал томилохоос татгалзсан бол санал гаргасан байгууллага, албан тушаалтан энэ зүйлд заасны дагуу өөр нэр дэвшигчийг санал болгоно;
- 6.9.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан Цэцийн гишүүнд тавих болзол, шаардлагыг хангах боломжтой хүмүүсийг судлах, ярилцлага хийх, нээлттэй, ил тод байх, олон нийтийн болон мэргэжлийн оролцоог хангах зэрэг асуудлыг зохицуулсан журмыг энэ хуульд нийцүүлэн баталж, ажлын таван өдрийн дотор цахим хуудсандаа байршуулна.
- 11.2.Цэцийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн нууцаар санал хурааж нийт гишүүний олонхын санал авсан хүнийг Цэцийн даргаар сонгоно. Цэцийн даргад гурав эсхүл түүнээс дээш гишүүн нэр дэвшиж, анхны санал хураалтаар хэн нь ч олонхын санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр гишүүний нэрээр дахин санал хурааж нийт гишүүний олонхын санал авсан гишүүнийг Цэцийн даргаар сонгоно;
- 11.5.Цэцийн даргын түр эзгүйд Цэцийн бүрэлдэхүүнд хамгийн удаан ажилласан гишүүн, хэрэв энэ шаардлагыг хэд хэдэн гишүүн нэгэн адил хангасан байвал тэдгээрийн хамгийн ахмад гишүүн Цэцийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэнэ;
- 12.2-т “Цэцийн тамгын газар дараах чиг үүргийг хэрэгжүүлж, Зөвлөгөөнд тогтмол тайлагнана.” гэж заасны:

- 12.2.1.Цэцийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй, аюулгүй явуулах, ажиллах нөхцөлөөр хангах, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;
- 12.2.2.Цэцэд ирсэн өргөдөл, мэдээлэл, хүсэлт, саналыг хүлээн авч, бүртгэх;
- 12.3.Тамгын газар тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ;
- 12.2.7.маргааны материал, баримтыг хадгалах, холбогдох шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 12.2.8.Цэцийн тээвэр, холбоо, мэдээлэл шинжилгээ, программ хангамж, дэвшилтэт техник, тоног төхөөрөмжөөр хангах, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах, түүнийг хэрэглэх мэргэжилтнээр хангах;
- 12.2.9.Цэцийн гадаад харилцааны асуудлыг хариуцан шаардлагатай баримт бичиг бэлтгэх, гадаад оронд айлчлах болон гадаадаас ирэх зочин, төлөөлөгчдийг хүлээн авах бэлтгэл хангах, тэдгээрт үйлчлэх;
- 12.2.10.Цэцийн цахим хуудасны мэдээллийг тогтмол шинэчлэх;
- 12.2.11.Цэцээс хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохион байгуулах;
- 12.2.12.Цэцийн бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлт, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг эрхлэх;
- 12.2.13.Цэцийн аж ахуй, санхүүг хөтлөн явуулах, төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах, санхүүгийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх;
- 12.2.14.Цэцийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээг авах;
- 12.2.16.Цэцийн гишүүн, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;
- 19.5.Энэ хуулийн 7.2.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол Цэцийн гишүүнд сүүлийн нэг жилийн албан тушаалын цалингийн дундаж хэмжээгээр тооцон 36 сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж эсхүл тэтгэвэрт гарсан бол холбогдох хуульд заасан тэтгэмжийг улсын төсвөөс олгоно;
- 19.7.Цэцийн гишүүнээр ажиллаж байсан хүний өндөр насны тэтгэврийг Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн 60-аас доошгүй хувиар бодож тогтооно;
- 20.1.Цэц аливаа байгууллага, албан тушаалтнаас бие даасан байж, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлөөр хангагдана;
- 20.2.Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн Цэцийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно;
- 20.3.Цэц тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд Цэцийн тамгыг Цэцийн дарга барина;
- 20.4.Цэц өөрийн бэлгэдэлтэй, Цэцийн гишүүн өмсгөл, энгэрийн тэмдэгтэй байх бөгөөд эдгээрийн загвар, хэрэглэх журмыг Дэгээр зохицуулна;
- 21.1.Цэц бие даасан төсөвтэй байх бөгөөд төсөв нь үйл ажиллагаагаа явуулахад хангалттай хүрэлцэхүйц байна;

- 21.2.Цэцийн төсөв, цалингийн сан, гишүүдийн цалин хөлсний хэмжээг Цэцийн даргын санал болгосноор Улсын Их Хурал тогтооно;
- 22.1.Цэц үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангасан өөрийн байртай байна.
- 22.2.Цэцийн байрны аюулгүй байдлыг төрийн тусгай хамгаалалтын байгууллага хариуцна гэх зохицуулалт.

Аргачлалын 4.4.6-д заасны дагуу төрийн байгууллагын бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээ буюу дараах дүрэм, журам, стандарт, кодчиллыг батлах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдох зардлыг тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 10.3.Зөвлөгөөн дараах асуудлыг хэлэлцэн хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ:
 - 10.3.1.Үндсэн хуулийн цэцийн дэгийг батлах;
 - 10.3.2.Бага, Дунд суудлын бүрэлдэхүүний хуваарийг жил бүр батлах;
 - 10.3.3.Цэцийн төсвийн талаар санал гаргах, төсвийн гүйцэтгэлтэй танилцах;
 - 10.3.4.Цэцийн даргыг сонгох, чөлөөлөх, огцруулах;
 - 10.3.5.Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэх;
 - 10.3.6.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэхийг тогтоох, энэ тухай шийдвэрээ Улсын Их Хуралд хүргүүлэх;
 - 10.3.7.Цэцийн тамгын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, дотоод журмыг батлах;
 - 10.3.8.Цэцийн даргын саналаар Цэцийн тамгын газрын дарга, Цэцийн судалгааны төвийн эрхлэгчийг, Цэцийн гишүүний саналаар түүний судлаачийг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;
 - 10.3.9.Цэцийн тамгын газрын үйл ажиллагааны тайлан, мэдээлэл сонсох, чиглэл өгөх;
 - 10.3.10.Цэцийн гишүүдийн гуравны нэгээс доошгүйн санал болгосон асуудал;
 - 10.3.11.хуульд заасан бусад.
- 10.4.Зөвлөгөөн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргана.
- 11.3.Цэцийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
 - 11.3.1.Цэцийг дотоод, гадаадад төлөөлөх;
 - 11.3.2.Зөвлөгөөнийг хуралдуулах, даргалах;
 - 11.3.3.төрийн бусад байгууллагатай харилцахдаа Цэцийн бие даасан байдлыг хамгаалах, хангах;
 - 11.3.4.Цэцийн төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
 - 11.3.5.Цэцийн тамгын газарт эрх хэмжээнийхээ хүрээнд чиглэл өгөх, хяналт тавих;
 - 11.3.6.хуульд заасан бусад.
- 11.4.Цэцийн дарга бүрэн эрхийнхээ хүрээнд захирамж, тушаал гаргана.
- 12.2.Цэцийн Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ дараах чиг үүргийг хэрэгжүүлж, Зөвлөгөөнд тогтмол тайлагнана:
 - 12.2.15.Цэцийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам баталж, мөрдүүлэх;
- 12.5.Тамгын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 12.5.1.Тамгын газрыг өдөр тутмын удирдлагаар хангах;
- 12.5.2.Цэцийн төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 12.5.3.Цэцийн төсвийн төслийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор хянуулахаар хүргүүлэх, хянасан төсвийн төслийн эцсийн хувилбарыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх, шаардлагатай бол Улсын Их Хурлаар Цэцийн төсвийг хэлэлцэх үед үг хэлэх;
- 12.5.4.Цэцийн гишүүний саналыг үндэслэн түүний туслахыг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;
- 12.5.5.Энэ хуулийн 12.5.4-т зааснаас бусад Тамгын газрын ажилтныг томилох, чөлөөлөх, сахилгын шийтгэл оногдуулах;
- 12.5.6.хуульд заасан бусад.
- 12.6.Тамгын газрын дарга бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргана.
- 20.5.Цэц, түүний гишүүний болон хуралдаанд оролцогчийн аюулгүй байдлыг хангах, хуралдааны дэг сахиулах үүргийг төрийн тусгай хамгаалалтын байгууллага гүйцэтгэх бөгөөд холбогдох журмыг Тамгын газрын дарга, төрийн тусгай хамгаалалтын байгууллагын дарга хамтран батална.
- 21.4.Цэцийн төсвийг боловсруулж батлахад дараах журмыг баримтална:
 - 21.4.1.Цэц өөрийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийн төслийг төлөвлөн Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хянуулахаар хүргүүлэх;
 - 21.4.2.Цэц Хууль зүйн байнгын хороогоор хянасан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хуульд заасны дагуу хүргүүлэх;
 - 21.4.3.Засгийн газар Цэцийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;
 - 21.4.4.Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Цэцийн санал, тайлбарыг сонсох, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх.
- 6.3-т “Улсын Их Хурал Цэцийн гишүүнд нэр дэвшигчийг санал болгохдоо дараах журмыг баримтална.” гэж заасны:
 - 6.3.1.Цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дууссан, эсхүл гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болсон өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор, хэрэв чуулганы чөлөө цагт эдгээр нөхцөл бий болсон бол ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийг тэнцвэртэйгээр, аль ч нам, эвсэл олонх болоогүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвслийг авсан суудлын тоогоор нь хувь тэнцүүлж бүрдүүлсэн 9 гишүүн бүхий ажлын хэсэг байгуулна. Нам, эвслийн бүлэг ажлын хэсгийн гишүүнээ өөрөө сонгоно.

Төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээнд хамаарах дараах зохицуулалтыг төрийн байгууллагын тухайлан зардал гаргах чиг үүрэгт хамааралгүй гэж үзэж тус тооцоонд тусгаагүй. Үүнд:

- 4.1.Үндсэн хуульд захирагдах, хууль дээдлэх, судалгаанд үндэслэх, тал үл харах, хараат бус, бие даасан, ил тод байх нь Цэцийн үйл ажиллагааны зарчим мөн;

- 5.1.Цэцийн гишүүн Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан болзлоос гадна дараах шаардлагыг хангана:
 - 5.1.1.эрх зүйч мэргэжилтэй;
 - 5.1.2.Цэцийн гишүүнээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй.
- 5.2.Дараах иргэнийг Цэцийн гишүүнээр томилохыг хориглоно:
 - 5.2.1.төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн;
 - 5.2.2.сүүлийн дөрвөн жилийн хугацаанд улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлсэн;
 - 5.2.3.албан тушаалаас огцруулах сахилгын шийтгэл хүлээсэн;
 - 5.2.4.сахилгын зөрчил гаргасны улмаас хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эсхүл өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг нь хүчингүй болгосон;
 - 5.2.5.эрүүгийн хариуцлага хүлээж байсан.
- 7.2.Цэцийн гишүүний бүрэн эрх дараах үндэслэлээр дуусгавар болно:
 - 7.2.1.нас барсан;
 - 7.2.2.бүрэн эрхийн хугацаа дуусаж дараагийн гишүүн томилогдсон;
 - 7.2.3.бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй тухай хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх хүсэлтийг үндэслэн Улсын Их Хурал чөлөөлсөн;
 - 7.2.4.Монгол Улсын иргэний харьяаллаас гарсан;
 - 7.2.5.энэ хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу Цэцийн гишүүнийг эгүүлэн татах тухай Улсын Их Хурлын шийдвэр гарсан;
 - 7.2.6.гэмт хэрэг үйлдсэн талаар шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.
- 7.3.Цэцийн гишүүнээр томилогдсоноос хойш төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн нь тухайн гишүүний бүрэн эрх дуусгавар болох үндэслэл болохгүй;
- 8.1.Цэцийн гишүүн томилогдсоноос хойш 30 хоногийн дотор “Үндсэн хуулийн цэцийн гишүүн би Монгол Улсын Үндсэн хуулийг чин үнэнчээр хамгаалж, маргааныг гагцхүү Үндсэн хуульд захирагдан тал үл харж, хараат бус, шударгаар хянан шийдвэрлэж, Цэцийн гишүүний үүргээ чандлан биелүүлэхээ тангараглая” хэмээн Цэцийн хуралдааны танхимд Үндсэн хуульд тангараг өргөнө;
- 10.2.Зөвлөгөөнд хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад Цэцийн гишүүн орно. Зөвлөгөөнийг долоогоос доошгүй гишүүн хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцох бөгөөд энэ хуульд өөрөөр заагаагүй бол Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ;
- 10.4.Зөвлөгөөн бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн тогтоол гаргана;
- 10.8.Цэцийн гишүүн Зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудалтай гурваас доошгүй ажлын өдрийн өмнө урьдчилан танилцах, санал гаргах, хуралдаанд оролцох тэгш боломжоор хангагдана;
- 10.9.Зөвлөгөөний шийдвэр үндэслэл бүхий, нийтэд ил тод, нээлттэй байх бөгөөд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд заасан шаардлагыг хангана;

- 14.3.Цэцийн гишүүн Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтыг дагаж мөрдөнө;
- 14.4.Цэцийн гишүүнд Төрийн албаны тухай хуулийн 39.1-д зааснаас гадна дараах зүйлийг хориглоно:
 - 14.4.1.бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээллийг задруулах, албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор ашиглах;
 - 14.4.2.Цэцэд хянан шийдвэрлэж байгаа маргаан эсхүл ойрын ирээдүйд Цэцийн шийдвэрлэвэл зохих асуудлын талаар саналаа нийтэд урьдчилан илэрхийлэх;
 - 14.4.3.өөрийн, эсхүл гэр бүлийн гишүүний эрх, ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх, хууль зүйн зөвлөгөө өгөх;
 - 14.4.4.багшлах болон судалгааны ажил гүйцэтгэхээс бусад албан үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;
 - 14.4.5.улс төрийн, худалдааны, эсхүл хараат бус, тал үл харах байдалд нь харшлах бусад үйл ажиллагаа эрхлэх, оролцох;
 - 14.4.6.хуульд заасан бусад.
- 17.1.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хараат бус байна;
- 17.2.Цэцийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд эрх тэгш байна;
- 17.3.Цэцийн гишүүний хараат бус байдалд халдсан, дордуулсан эрх зүйн акт гаргахыг хориглоно;
- 17.4.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Улсын ерөнхий прокурор, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шууд болон шууд бусаар нөлөөлөхийг хориглоно;
- 18.1.Цэцийн гишүүний амь бие, орон сууц, ажлын байр, тээвэр, холбооны хэрэгсэл, захидал харилцаа халдашгүй байна;
- 18.2.Албан үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай материал, техник, тээврийн хэрэгсэл, бие хамгаалах тусгай хэрэгслээр Цэцийн гишүүнийг хангана;
- 18.3.Энэ хуульд зааснаас бусад тохиолдолд Цэцийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, эгүүлэн татах, өөр ажилд шилжүүлэхийг хориглоно;
- 18.5.Цэцийн гишүүн, эсхүл түүний гэр бүлийн гишүүний амь нас, аюулгүй байдалд аюул занал учрах нөхцөл үүссэн бол цагдаагийн байгууллага таслан зогсоход чиглэсэн арга хэмжээг нэн даруй авна;18.6.Цэцийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд аливаа албан дайчилгаанаас чөлөөлөгдөнө;
- 19.1.Цэцийн гишүүний албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байна;

- 19.2.Цэцийн гишүүний цалин хөлс нь албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдлээс бүрдэнэ;
- 19.3.Цэцийн төсвийг батлахдаа гишүүний цалин хөлсний хэмжээг өмнөх жилийнхээс бууруулж болохгүй;
- 19.4.Цэцийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон зардлыг Цэцийн төсвөөс санхүүжүүлнэ;

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл, заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл, заалт
<p>3 дугаар зүйл. Үндсэн хуулийн цэц, түүний бүрэн эрх</p> <p>3.2.Цэц энэ хуулийн 3.1-д заасан бүрэн эрхээ дараах замаар хэрэгжүүлнэ:</p> <p>3.2.5.үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх.¹</p>	<p>3.1.Цэц Үндсэн хуулийг чандлан сахиулах, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа болж, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэх Үндсэн хуулийн шүүх мөн.</p> <p>9.1.Цэц маргааныг Бага, Дунд, Их суудлаар хянан шийдвэрлэнэ.</p> <p>9.2.Цэцэд гурван гишүүний бүрэлдэхүүнтэй Бага суудал гурав, зургаан гишүүний бүрэлдэхүүнтэй Дунд суудал гурав, нийт гишүүний бүрэлдэхүүнтэй Их суудал нэг байна.</p> <p>9.4.Цэцийн гишүүн Бага суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.</p> <p>9.5.Цэцийн гишүүн Дунд суудлын хоёроос илүү бүрэлдэхүүнд нэгэн зэрэг харьяалагдахгүй.</p> <p>9.6.Бага эсхүл Дунд суудлын бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд бусад бүрэлдэхүүнээс энэ хуулийн 9.7-д заасан журмын дагуу Цэцийн гишүүнийг томилон ажиллуулж болох бөгөөд үүнд энэ хуулийн 9.4, 9.5-д заасан</p>

¹ Үндсэн эрхийн маргааныг магадлан шийдвэрлэх чиг үүрэг Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн болон Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан бөгөөд уг чиг үүрэгт холбогдох зардлыг давхардуулж тооцохгүй байх үүднээс энэхүү зардлын тооцоонд оруулаагүй болно. Иймд дээрх чиг үүрэгтэй холбоотой зардлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлангаас үзнэ үү.

	<p>хязгаарлалт хамаарахгүй.</p> <p>9.7.Өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авах, Бага суудалд хуваарилах, Бага, Дунд суудлын бүрэлдэхүүн, хуралдаан даргалагч, илтгэгч гишүүнийг томилх, маргааныг Дунд суудалд хуваарилахдаа урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор сонгох нөхцөлийг хангах бөгөөд холбогдох журмыг Дэгээр зохицуулна.</p>
<p>10.1.Цэцийн нийт гишүүнээс бүрдсэн Цэцийн зөвлөгөөн /цаашид “Зөвлөгөөн” гэх/ ажиллана.</p>	<p>10.5.Тамгын газар Зөвлөгөөний хуралдааныг тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивын нэгж үүсгэн хадгална.</p> <p>10.6.Энэ хуулийн 10.3-т заасан дэг, хуваарь, дотоод журам нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд тэдгээрийг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор Цэцийн цахим хуудсанд байршуулна.</p> <p>10.7.Зөвлөгөөн ээлжит болон ээлжит бус хэлбэртэй байна. Ээлжит Зөвлөгөөнийг улиралд нэгээс доошгүй удаа, ээлжит бус Зөвлөгөөнийг Цэцийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй, эсхүл Цэцийн даргын саналаар хуралдуулна.</p>
<p>12.1.Цэц Тамгын газартай байна: 12.2.Цэцийн Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/ дараах чиг үүргийг хэрэгжүүлж, Зөвлөгөөнд тогтмол тайлагнана:</p>	<p>12.2.3.маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, тодорхой маргааны насжилт зэрэг үзүүлэлтээр гаргах, хяналт-шинжилгээ хийх, нийтэд мэдээлэх;</p> <p>12.2.4.маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах, ийм санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчлэх, номын сангийн үйлчилгээ үзүүлэх;</p> <p>12.2.5.Цэцийн хуралдаан, Зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажиллагаа, техникийн болон бусад бэлэн байдлыг хангах, хуралдааны товыг нийтэд мэдээлэх, тэмдэглэн хөтөлж, хадгалах;</p> <p>12.2.6.Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх, хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;</p>

	<p>12.4.Тамгын газрын дарга Төрийн албаны тухай хуульд заасан шаардлага хангасан төрийн захиргааны албан тушаалтан байна.</p>
<p>12.8. Ерөнхий бүртгэгч нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасны дагуу өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг шаардлага хангасан эсэх, Цэц урьд нь тухайн асуудлыг шийдвэрлэсэн эсэхийг нягтлан үзэж, тухайн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагч этгээдэд өгөх чиг үүрэгтэй. Ерөнхий бүртгэгч энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд бүртгэгч тусална.</p>	<p>12.7.Цэцэд Ерөнхий бүртгэгч, бүртгэгч ажиллах бөгөөд тэдгээр нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй, мэргэжлээрээ гурваас доошгүй жил ажилласан байна.</p>
<p>13.2.Туслах нь эрх зүйч байх бөгөөд Цэцийн гишүүний удирдлага дор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.</p>	<p>12.9.Цэцийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий судалгааны төв, номын сан болон зохион байгуулалтын бусад нэгж ажиллана.</p> <p>13.1.Цэцийн гишүүн нэг туслахтай байна.</p> <p>13.3.Цэцийн гишүүн энэ хуулийн 13.1-д зааснаас гадна Цэцийн гишүүний удирдлага дор маргаан хянан шийдвэрлэхтэй холбоотой судалгаа хийх чиг үүрэг бүхий гурав хүртэл судлаачтай байна. Судлаач нь харьцуулсан эрх зүйн судалгаа хийх чадвартай, энэ хуулийн 5.2-т заасан шаардлага хангасан эрх зүйч байна.</p> <p>13.4.Цэцийн гишүүн нь их, дээд сургууль, төрийн бусад байгууллагын удирдлагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр тухайн байгууллагын албан хаагчийг Цэцийн гишүүний судлаачаар хоёр жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.</p>

	<p>13.5.Энэ хуулийн 13.4-т заасан албан хаагч өөрөө, эсхүл Цэцийн гишүүний хүсэлтээр анх илгээсэн байгууллага болон өөрийнх нь зөвшөөрснөөр сэлгэн ажиллуулах хугацааг нэг жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Албан хаагчийг сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүй.</p>
<p>17.5.Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.</p>	<p>17.6.Цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар маргаан үүсгэсэн даруйд тухайн маргааны оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулна.</p> <p>17.7.Цэцийн гишүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол маргааны материалд хавсаргаж, хувийг Тамгын газарт хүргүүлнэ.</p> <p>17.8.Тамгын газар нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд шилжүүлнэ.</p> <p>17.9.Энэ хуулийн 17.8-д заасны дагуу шилжүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн байгууллага, албан тушаалтан шийдвэрлэж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн Цэцийн гишүүн болон Тамгын газарт хариу мэдэгдэнэ.</p> <p>17.10.Тамгын газар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</p>
<p>16.3.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэрийг Зөвлөгөөнд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар гаргах бөгөөд нууц санал хураалтаар шийдвэрлэнэ.</p>	<p>16 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах</p> <p>16.1.Энэ хуулийн 14.2, 14.3, 14.4-т заасан үүрэг, хориглолт, хязгаарлалтыг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн нь Цэцийн гишүүний албан тушаалыг эрхлэхэд тохирохгүйг харуулсан бол тухайн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл /цаашид “Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл” гэх/ болно.</p> <p>16.2.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлыг Зөвлөгөөн энэ тухай гомдлын дагуу хянан шийдвэрлэнэ. Уул асуудалд холбогдсон Цэцийн гишүүн Зөвлөгөөний хуралдаанд үг хэлэх</p>

эрхтэй бөгөөд санал хураалтад оролцохгүй.

16.4.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэр гаргасан бол ажлын таван өдрийн дотор уг шийдвэрийг Улсын Их Хурал болон тухайн гишүүнийг анх илгээсэн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж нийтэд мэдээлнэ. Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан Зөвлөгөөний шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор саналаа Улсын Их Хуралд хүргүүлнэ.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасны дагуу Зөвлөгөөний шийдвэрийг Улсын Их Хурал чуулганы үеэр хүлээн авсан бол ажлын таван өдрийн дараа 14 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлсэн өдрөөс хойш 14 хоногийн дотор Зөвлөгөөний шийдвэр, анх илгээсэн байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл бий эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

16.6.Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан энэ хуулийн 16.4-т заасан хугацаанд Улсын Их Хуралд саналаа ирүүлээгүй бол тухайн асуудлаар тусгайлан өгөх саналгүй гэж үзэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

19.6.Энэ хуулийн 7.2.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах үүргийг тухайн байгууллага, ажил олгогч хүлээх бөгөөд ийм боломжгүй тохиолдолд түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар төр хангана. Тийм боломжгүй бол ажил эрхлэх хүртэлх гурван жилийн хугацаанд Цэцийн гишүүн байсан үеийн авч байсан цалингийн хэмжээнээс бууруулахгүйгээр тэтгэмжийг сар бүр олгоно. Бага цалинтай ажил эрхэлж байгаа бол өндөр насны тэтгэвэрт гарах хүртэл цалингийн зөрүүг улсын төсвөөс сар бүр олгоно.

<p>19.8.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд дараах баталгаагаар хангагдана:²</p> <p>19.8.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол авч байсан цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгох;</p> <p>19.8.2.хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, авч байсан цалин хөлсний зөрүүг олгох;</p> <p>19.8.3.хиймэл эд, эрхтэн хийлгэх бол түүний зардал, түүнчлэн гишүүнд туслалцаа, үйлчилгээ үзүүлэх ажилтны хөлс олгох.</p>	
<p>19.9.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан тохиолдолд 60 сарын, өвчний улмаас нас барсан бол 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгоно.</p>	<p>Энэ нь бусад төрийн албан хаагчтай төсөөтэй баталгаа, одоо хэрэгжиж байгаа хуульд хэдий тусгаагүй байгаа ч бусад хуулийн үйлчлэлээр хэрэгжиж байгааг харгалзаж , энэ төрлийн зардалтай холбоотой тайлбар буюу өөрөөр хэлбэл нарийвчилж тооцоогүйтэй холбогдох тайлбарыг энд оруулах уу, яах уу</p>

2.1. Төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

² Одоо хэрэгжиж байгаа хуульд дээрх баталгаа тусгаагүй байгаа ч төрийн албан хаагчийн нийтлэг баталгаатай төсөөтэй бөгөөд бусад хуулийн үйлчлэлээр хэрэгжиж байгааг харгалзаж энэхүү зардлын тооцоонд нарийвчлан тооцоогүй болно.

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Хэрэгжүүлэх, хэмжих боломжтой чиг үүргийг хамруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хүрээнд төрийн байгууллагаас хэрэгжүүлэх бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй. Иймд гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг дараах ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
Үндсэн хуулийн цэц	Цэцийн хуралдаан, Зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажиллагаа, техникийн болон бусад бэлэн байдлыг хангах, хуралдааны товыг нийтэд мэдээлэх, тэмдэглэн хөтөлж, хадгалах	<ul style="list-style-type: none"> - Зөвлөгөөний хуралдааны бэлтгэлийг хангах; - Зөвлөгөөний хуралдааны товыг нийтэд мэдээлэх; - Зөвлөгөөний хуралдааныг тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивын нэгж үүсгэн хадгалах; - 10.3-т заасан дэг, хуваарь, дотоод журмыг Цэцийн цахим хуудсанд байршуулах.
	Маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, тодорхой маргааны насжилт зэрэг үзүүлэлтээр гаргах, хяналт-шинжилгээ хийх, нийтэд мэдээлэх	<ul style="list-style-type: none"> - маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг тогтоосон үзүүлэлтээр гаргах; - маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээлэлд хяналт шинжилгээ хийх; - маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг нийтэд мэдээлэх.
	Маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах, ийм санг цахим болон цаасан хэлбэрээр	<ul style="list-style-type: none"> - маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах; - маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчлэх;

	<p>бүрдүүлж, шинэчлэх, сангийн үзүүлэх</p> <p>тогтмол номын үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> - номын сангийн үйлчилгээ үзүүлэх.
	<p>Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх, хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг цахим хуудаст байршуулах зэргээр нийтэд мэдээлэх; - Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг эмхэтгэн хэвлэх; - Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх;
	<p>Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэж, Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагч этгээдэд өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэх; - Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг бэлтгэх; - Хариуг маргагч этгээдэд өгөх, танилцуулах.
	<p>Туслах нь Цэцийн гишүүний удирдлага дор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх баримт бичгийн бүрдлийг судалж, Цэцийн гишүүнд танилцуулах; - хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан Гишүүнээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх; - Гишүүний үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх; - хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр туслах; - хэргийг товъёглон хөтлөх; - тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах; - хуралдааны бэлтгэл, зохион

		<p>байгуулалтыг хангахад оролцох;</p> <ul style="list-style-type: none"> - Цэцийн шийдвэр, тогтоол, Даргын захирамжийн төсөл боловсруулах.
	<p>Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.</p>	<ul style="list-style-type: none"> - Цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар маргаан үүсгэсэн даруйд тухайн маргааны оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулах;Цэцийн гишүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол маргааны материалд хавсаргаж, хувийг Тамгын газарт хүргүүлэх;Тамгын газар нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх; - Эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн Цэцийн гишүүн болон Тамгын газарт хариу мэдэгдэх; - Тамгын газар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлэх.
	<p>Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлыг Зөвлөгөөн энэ тухай гомдлын дагуу хянан шийдвэрлэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Зөвлөгөөний хуралдааныг хуралдуулж шийдвэрлэх; - Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэр гаргасан бол ажлын таван өдрийн дотор уг шийдвэрийг Улсын Их Хурал болон тухайн гишүүнийг анх илгээсэн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж нийтэд мэдээлэх; - Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан Зөвлөгөөний шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор саналаа Улсын Их Хуралд хүргүүлэх; - Улсын Их Хурал Зөвлөгөөний шийдвэр, анх илгээсэн байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл бий эсэх асуудлыг шийдвэрлэх; - Хуулийн 7.2.2-т заасан

		үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар төр хангах, эсхүл тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх.
--	--	--

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд **зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо** /цаашид “тохиолдлын тоо” гэх/, **шаардагдах нийт ажлын цаг** гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистик тоон мэдээллийг тооцсон болно.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэгдэх тохиолдлын тоог тооцохдоо Улсын Дээд шүүх(цаашид, УДШ)-ийн 2022 оны маргаан шийдвэрлэсэн статистик тоог баримталлаа. Үүнд:

Хүснэгт 11. УДШ-ийн хэрэг маргаан шийдвэрлэсэн тоон үзүүлэлт /2022 он/

	Эрүүгийн хэрэг	Иргэний хэрэг	Захиргааны хэрэг	Нийт
УДШ-д ирсэн гомдлын тоо	1108	2701	550	4,359
УДШ-ээс хянан шийдвэрлэсэн маргааны тоо	431	1,652	190	2,273
Тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тохиолдлын тоо	37	401	16	454

Эх сурвалж: . Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэний өргөдлөөр маргаан хянан шийдвэрлэгдэх тохиолдлын тоог тооцохдоо Улсын Дээд шүүх(цаашид, УДШ)-ийн 2022 оны маргаан шийдвэрлэсэн статистик тоог баримталлаа.

Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахаас өмнө эрхээ сэргээлгэхээр бүх шатны шүүхийн механизмыг ашигласан байхыг шаардана. Иймд УДШ-ээс иргэний гомдлыг хүлээн авч, хянан хэлэлцээд тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн тоогоор Үндсэн хуулийн цэцийн иргэний өргөдлийг хянан шийдвэрлэх чиг үүргийн тохиолдлын тоог тооцов. УДШ-ээс 2022 онд 4,359 гомдлыг хүлээн авснаас 454 тохиолдолд нь тогтоол, магадлалыг хэвээр үлдээсэн байна. Иймд дээрх тооны гомдлыг өргөдөл хэлбэрээр Үндсэн хуулийн цэц хүлээн авна гэж үзэн тооцоо хийсэн.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл бүрээр маргаан үүсгэдэггүй тул маргаан үүсгэх магадлалыг дараах тоон мэдээлэлд үндэслэн дунджаар тогтоов. Үүнд:

Хүснэгт 12. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мэдээлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийн тоон мэдээ /2018-2022 он/

№	Төрөл	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1.	Гомдол	33	45	37	23	36
2.	Мэдээлэл	174	137	121	133	97
3.	Өргөдөл	28	64	31	28	54
5.	Хүсэлт	4	2	-	3	-
	Нийт:	237	248	189	187	187

Хүснэгт 13. Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдөл, мэдээлэл, гомдлыг Тамгын газраас буцаасан байдлын тоон мэдээ

№	Өргөдөл, мэдээллийг буцаасан байдлын тоо
2022	46
2021	47
2020	46
2019	45
2018	29

Хүснэгт 14. Үндсэн хуулийн цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоолын тоон мэдээ

№	Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоолын тоо
2022	64
2021	72
2020	84
2019	91
2018	94

Дээрх статистикаас дүгнэвэл, Үндсэн хуулийн цэц жилд дунджаар 192 өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг хүлээн авдаг бөгөөд үүнээс ойролцоогоор 43-ыг буцааж, 81-т нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэхээс татгалздаг байна. Өөрөөр хэлбэл, нийт өргөдлийн 35 хувийг хүлээн авч шийдвэрлэдэг.

Иймд УДШ-ээс магадлал, шийдвэрийг хэвээр үлдээсэнтэй холбоотойгоор 454 иргэн Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргана гэж үзвэл, Үндсэн хуулийн цэц түүний 35 хувийг буюу 159 хэрэг шийдвэрлэнэ хэмээн тооцоонд тусгалаа.

Харин эрх бүхий байгууллагын хүсэлтээр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг шийдвэрлэх тохиолдлын тоог тогтоохдоо жилд дунджаар 2 хүсэлт ирнэ гэж үзэв.

Бусад төрлийн өргөдөл, гомдол жилд дунджаар 76 байх тул дээр дурдсан төрлийн гомдол, мэдээлэл, өргөдөл, хүсэлтийн нийт дундаж тоог 373 гэж үзэв.

УДШ-ээс 2022 онд 4,359 гомдлыг хүлээн авснаас 2,243 хэргийг шийдсэн бөгөөд ингэхдээ нийт 15 нөлөөллийн мэдүүлгийг Шүүхийн ерөнхий зөвлөл хүргэсэн байгаагаас үзвэл нийт хэргийн 0.6 хувьд шүүгчид нөлөөлөх оролдлого хийдэг гэж үзэж, Үндсэн хуулийн цэцээс нөлөөллийн мэдүүлгийг эрх бүхий байгууллагад хүргүүлэх тохиолдлын тоог 0.5 гэж үзэв.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа	Тохиолдлын тоо	Зарцуулах хугацаа	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
Цэцийн хуралдаан, Зөвлөгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажиллагаа, техникийн болон бусад бэлэн байдлыг хангах, хуралдааны товыг нийтэд мэдээлэх, тэмдэглэн хөтөлж, хадгалах	Зөвлөгөөний хуралдааны бэлтгэлийг хангах	1	96000	96000
	Зөвлөгөөний хуралдааны товыг нийтэд мэдээлэх			
	Зөвлөгөөний хуралдааныг тэмдэглэл хөтлөн баримтжуулж, архивын нэгж үүсгэн хадгалах	1	96000	96000
	10.3-т заасан дэг, хуваарь, дотоод журмыг Цэцийн цахим хуудсанд байршуулах	10	60	600
Маргаан хянан шийдвэрлэх статистик	маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг тогтоосон	1	96000	96000

мэдээллийг хянан шийдвэрлэх дундаж хугацаа, тодорхой маргааны насжилт зэрэг үзүүлэлтээр гаргах, хяналт-шинжилгээ хийх, нийтэд мэдээлэх	үзүүлэлтээр гаргах,			
	маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээлэлд хяналт шинжилгээ хийх			
	маргаан хянан шийдвэрлэх статистик мэдээллийг нийтэд мэдээлэх			
Маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах, ийм санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчлэх, номын сангийн үйлчилгээ үзүүлэх	маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа хийх, мэдээлэл, судалгаа, хууль тогтоомжоор хангах	1	96000	96000
	маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай санг цахим болон цаасан хэлбэрээр бүрдүүлж, тогтмол шинэчлэх	1	96000	96000
	номын сангийн үйлчилгээ үзүүлэх	1	96000	96000
Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх, хүргүүлэх, цахим хуудаст байршуулах, эмхэтгэн хэвлэх, хайлт хийх боломжтой цахим сан бүрдүүлэх, тогтмол шинэчлэх	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг нийтэд мэдээлэх;	1	96000	96000
	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг эмхэтгэн хэвлэх	1	96000	96000
	Цэцийн шийдвэр, Цэцийн гишүүний тусгай саналыг хайлт хийх боломжтой цахим сан төвлөрүүлэх, тогтмол шинэчлэх;	1	96000	96000
Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэж, Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг маргагч этгээдэд өгөх	Ерөнхий бүртгэгч нь өргөдөл, мэдээлэл, хүсэлтийг нягтлан үзэх	1	96000	96000
	Цэцээр хянан шийдвэрлэх бүртгэлд бүртгэсэн эсэх талаар үндэслэл бүхий хариуг бэлтгэх			
	Хариуг маргагч этгээдэд өгөх, танилцуулах			

Туслах нь Цэцийн гишүүний удирдлага дор Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 89.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ	Цэцэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх баримт бичгийн бүрдлийг судалж, Цэцийн гишүүнд танилцуулах;	9	96000	864000
	хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан Гишүүнээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх;			
	Гишүүний үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;			
	хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр туслах;			
	хэргийг товьёглон хөтлөх;			
	тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах;			
	хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад оролцох;			
	Цэцийн шийдвэр, тогтоол, Даргын захирамжийн төсөл боловсруулах;			
Цэцийн гишүүн маргаан хянан шийдвэрлэх явцад бусад этгээдээс нөлөөлөхөөр оролдсон үйлдэл, эс үйлдэхүйг тэмдэглэн баталгаажуулах зорилгоор нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.	Цэцийн гишүүний нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар маргаан үүсгэсэн даруйд тухайн маргааны оролцогчид тайлбарлан, энэ тухай баримтжуулах	159	10	1590
	Цэцийн гишүүн нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн бол маргааны материалд хавсаргаж, хувийг Тамгын газарт хүргүүлэх	0.5	120	60
	Тамгын газар нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн	0.5	60	30

	баталгаажуулсан үйлдлийг шалгуулахаар зохих байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх			
	Эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэрлэж, нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн Цэцийн гишүүн болон Тамгын газарт хариу мэдэгдэх	0.5	60	30
	Тамгын газар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүр мэдээлэх	0.5	60	30
Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлыг Зөвлөгөөн энэ тухай гомдлын дагуу хянан шийдвэрлэнэ.	Зөвлөгөөний хуралдааныг хуралдуулж шийдвэрлэх Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй тухай шийдвэр гаргасан бол ажлын таван өдрийн дотор уг шийдвэрийг Улсын Их Хурал болон тухайн гишүүнийг анх илгээсэн байгууллага, албан тушаалтанд хүргүүлж нийтэд мэдээлэх Анх илгээсэн байгууллага, албан тушаалтан Зөвлөгөөний шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор саналаа Улсын Их Хуралд хүргүүлэх Улсын Их Хурал Зөвлөгөөний шийдвэр, анх илгээсэн байгууллага, албан тушаалтны саналыг үндэслэн Цэцийн гишүүнийг эгүүлэн татах үндэслэл бий эсэх асуудлыг шийдвэрлэх Хуулийн 7.2.2-т заасан үндэслэлээр бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон бол гишүүнээр томилогдохын өмнөх ажилд нь эгүүлэн	1	96000	96000

	ажиллуулах, эсхүл түүнтэй тэнцэх цалин хангамж бүхий ажлаар төр хангах, эсхүл тэтгэмж олгох асуудлыг шийдвэрлэх			
				Нийт
				1 922 340

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөлд тусгасан нэмэлт чиг үүргийг гүйцэтгэхэд 1 922 340 минут шаардагдахаар байна. Гэвч энэ дүнгээс Цэцийн гишүүний туслахын Шүүхийн тухай хуульд заасан чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай гэж үзсэн 864 000 минутыг цаашид хасаж тооцох нь ҮХЦМХШТХ-ын шинэчилсэн найруулгын төслийн зардлын тооцоотой зарим хэсгээр давхцахаас сэргийлнэ.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагад нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
Үндсэн хуулийн цэц	1,058,340	96.000	11

Өнөөгийн байдлаар Үндсэн хуулийн цэц цэцийн гишүүн-9, бүртгэлийн ажилтан-3, туслах буюу шинжээч- 9, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга-1, судлаач-5, Хууль зүйн газрын дарга-1, нийт 28 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулдаг. Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэрэгжихтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд Ерөнхий бүртгэгч, бүртгэгч, мэдээлэл оруулагч, номын санч, судлаач зэрэг нийт 11 албан хаагч (гишүүний туслах ороогүй) нэмэгдэхээр байна.

2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төслийн хувьд, улсаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардлыг эхэлж тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Үндсэн хуулийн цэц маргаан хянан шийдвэрлэхэд бүртгэлийн ажилтан, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шинжээч, судлаач зэрэг бусад албан хаагч оролцдог. Тэдгээр албан хаагчид нь Засгийн газрын 2020 оны 75 дугаар тогтоолоор батлагдсан “Засгийн газрын ажлын албаны албан тушаалын цалингийн сүлжээ”-ээр цалинждаг. Уг цалингийн сүлжээг үндэслэн тэдгээр албан хаагчдын дундаж цалинг 1,500,000 төгрөг гэж үзвэл нэг жилд 18,000,000 төгрөг, түүний НДШ зардалд 2,250,000 төгрөг, нийт 20,250,000 төгрөг зардал гарна гэж тооцооллоо.

Нэгж зардлыг **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
Үндсэн хуулийн цэц	11	20,250,000	222,750,000

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал болон холбогдох бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

“Материаллаг зардал” гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	124,000
	Ном, хэвлэл авах	54,745
	Шуудан холбоо	306,812

	Компьютер, тоног төхөөрөмж	2,500,000
	Тавилга, эд хогшил	1,000,000
Зардал	Түлш, халаалт	263,408
	Гэрэл, цахилгаан	128,239
	Цэвэр, бохир ус	599,438
	Урсгал засвар	127,752
	Газрын төлбөр	22,253
Элэгдэл,хорогдлы нзардал	Техник, тоног төхөөрөмж	300,000
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,526,647
Нийт		110,532,940

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 8. Нийт зардал

Төрөл	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
Нийт зардлын хэмжээ	222,750,000	60,793,117	283,543,117

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэрэгжихтэй холбоотойгоор Үндсэн хуулийн цэцэд Ерөнхий бүртгэгч, бүртгэгч, мэдээлэл оруулагч, номын санч, судлаач, туслах зэрэг нийт 20 албан хаагч нэмэгдэх бөгөөд тэдгээрийн хүний нөөцийн зардал, материаллаг зардалд жилд ойролцоогоор 515,532,940 төгрөг шаардлагатай. Түүнчлэн хуулийн төсөлд зардалд нөлөөлөх дараах зохицуулалт байгааг анхаарах нь зүйтэй.

19.8.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэж яваад эрүүл мэнд нь хохирсон тохиолдолд дараах баталгаагаар хангагдана:

19.8.1.хөдөлмөрийн чадвараа түр алдсан бол авч байсан цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгох;

19.8.2.хөгжлийн бэрхшээлтэй болсон тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, авч байсан цалин хөлсний зөрүүг олгох;

19.8.3.хиймэл эд, эрхтэн хийлгэх бол түүний зардал, түүнчлэн гишүүнд туслалцаа, үйлчилгээ үзүүлэх ажилтны хөлс олгох.

19.9.Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэх үедээ амь насаа алдсан тохиолдолд 60 сарын, өвчний улмаас нас барсан бол 36 сарын албан тушаалын цалинтай нь тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж ар гэрт нь олгоно.

Одоо хэрэгжиж байгаа хуульд дээрх баталгаа тусгаагүй байгаа ч төрийн албан хаагчийн нийтлэг баталгаатай төсөөтэй бөгөөд бусад хуулийн үйлчлэлээр хэрэгжиж байгааг харгалзаж энэхүү зардлын тооцоонд нарийвчлан тооцоогүй болно.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

- 1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;
- 2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;
- 3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;
- 4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;
- 5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Үндсэн хуулийн цэцийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/- д тусгагдсан чиг үүргүүд нь жилийн туршид тасралтгүй үргэлжлэх шинжтэй байх тул тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн. Иймд тохиолдлын тоог дахин багасгах боломжгүй. Түүнчлэн Зөвлөгөөний хуралдааны тов, зохих шийдвэр, хуульд заасан дүрэм, журам, дэгийг олон нийтэд мэдээлэх, Үндсэн хуулийн цэцийн шийдвэр, гишүүний тусгай санал, мэдээллийг нийтэд ил тод нийтлэх, мэдээллийн санг үүсгэх нь шүүхэд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэх онцгой ач холбогдолтой байх тул олон нийтэд мэдээлэх мэдээллийн агуулгыг багасгах, давтамжийг бууруулах нь оновчтой шийдэл биш юм.

Харин маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай судалгаа, мэдээллийн санг бүрдүүлэх, тогтмол шинэчлэх чиг үүргийг цахим болон цаасан хэлбэрээр гүйцэтгэх талаар хуулийн төсөлд дурдсан тул тус санг оновчтой зохион байгуулж, хөгжүүлэх ажлыг анхаарах нь зүйтэй.

III. ДҮГНЭЛТ, САНАЛ

Хуулийн төсөлд зардлын тооцоо хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой. Үүний хүрээнд, Үндсэн хуулийн цэцийн тухай хууль/Шинэчилсэн найруулга/-ийн төсөл батлагдсанаар үүсэх зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ыг баримтлан тооцов.

Нэг. Төрийн байгууллагад үүсэх зардлын тооцоо

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөлд тусгасан нэмэлт чиг үүргийг хэрэгжүүлэхэд 11 албан хаагч нэмэлтээр шаардлагатай бөгөөд үүнтэй холбоотойгоор хүний нөөцийн болон бусад материаллаг зардалд жил ойролцоогоор 283,543,117 төгрөг зарцуулах шаардлагатай. Цэцийн гишүүний туслахын хэрэгжүүлэх чиг үүрэг болон үндсэн эрх зөрчигдсөн талаарх гомдолтой холбоотой маргаан хянан шийдвэрлэх чиг үүргийг энэхүү тооцоонд оруулаагүй болно. Уг чиг үүрэгтэй холбоотой зардлыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хууль/Шинэчилсэн найруулга/ -ийн төсөлд хийсэн зардлын тооцоонд тусгасан.

Хоёр. Зардал-үр өгөөжийн үнэлгээ

Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн төсөл батлагдсанаар дагалдан гарах зардал хэдийгээр нэмэгдэх хандлагатай боловч хуулийн төслийн үр өгөөжтэй харьцуулахад үр өгөөж нь илүү учир зардлыг байж болохуйц хэмжээ гэж дүгнэв.

